



Хураангуй зөвлөмж

- ХАА-н салбарт мэдээллийн гүйцэтгэх үүргийг бүрэн ашиглах, бодлогын төвшинд анхаарал хандуулах
- Мэдээлэл түгээхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ, төрөлжсөн хэвлэлийн бүтээгдэхүүнүүд, сургалт мэдээллийн арга хэмжээ ба хүмүүс хоорондын харилцааг үр дүнтэйгээр хослуулан ашиглах
- Мэдээлэл, сурталчилгааны ажлыг жил бүрээр төлөвлөж, төсвийг ХХААХҮЯ, бусад эх үүсвэрүүдээс бүрдүүлэх замаар салбарын ба олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах
- ХАА-н цахим мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгож, ХААҮШҮОНТ-д хариуцуулах
- ХАА-н мэдээллийн нэгдсэн сан байгуулж, ХААҮШҮОНТ-д хариуцуулах
- Цахим сургалтын санаачлагуудыг үнэлж дүгнэх, хэрэглээг нь нэмэгдүүлэх
- ХХААХҮЯ-ны хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны тоноглол, хүний нөөцийг сайжруулах
- Салбарын сэтгүүлчид, бусад мэдээ, мэдээлэл бэлтгэгчдийг сургалтанд хамруулж, чадавхжуулах
- ХАА-н үйлдвэрлэгчдийг цахим мэдээлэлтэй харьцах, цахим контент бэлтгэх зайны сургалтад хамруулах
-

Хөдөө аж ахуйн салбарт мэдээллийн хүртээмж, чанарыг сайжруулах чиглэл, арга замууд

Монгол улсын Засгийн газраас ХАА-н салбарт хэрэгжүүлж буй бодлого, эрх зүйн шинэчлэлүүдийн хэрэгжилт, үр дүн, салбарын хөгжилд саад болж буй нэг асуудал бол мэдээллийн хүртээмж, чанарын дутагдал юм. Тус салбарт ажиллаж буй малчид, тариаланчид, байгууллага, ААН-үүдэд чанартай мэдээллийг цаг тухайд нь хүргэх нь шинээр батлагдсан хууль, журам, бодлогын шийдвэрүүдийг таниулж сурталчлах, нийт ХАА-н салбарын тогтвортой байдал ба бодлого, эрх зүй, байгаль, нийгэм, эдийн засаг, зах зээлийн орчны өөрчлөлтүүдэд дасан зохицох чадварыг хангах суурь нөхцөлд тооцогдоно. Энэхүү бодлогын зөвлөмжид ХАА-н салбар дахь мэдээллийн хангамжийн өнөөгийн байдлын товч дүгнэлтэд үндэслэн цаашид мэдээллийн хүртээмж, чанарыг сайжруулах үндсэн чиглэлүүдийг тодорхойлж, эн тэргүүнд хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнүүдийг санал болгож байна.

Хөдөө аж ахуйн мэдээллийн төрөл, ач холбогдол

ХАА-н өртгийн сүлжээний шат дамжлага бүрт тухайн оролцогч талууд (ХАА-н үйлдвэрлэгчид, боловсруулах үйлдвэрүүд, эрдэмтэн судлаачид, зөвлөх мэргэжилтнүүд, төр захиргаа, мэргэжлийн хяналтын байгууллагууд, хувийн хэвшлийн ААН-үүд г.м.) шийдвэр гаргахдаа ашиглаж буй мэдээллийг нийтэд нь “хөдөө аж ахуйн мэдээлэл” гэсэн нэр томъёогоор илэрхийлж болно. ХАА-н мэдээллийг хялбарчилсан байдлаар дараахь төрлүүдэд ангилна:

- Бодлого, эрх зүйн мэдээлэл: хууль, дүрэм, журам, заавар, бодлогын шийдвэр, зөвлөмж, сурталчилгаа г.м.,

Implemented by



- Үйлдвэрлэлийн мэдээлэл: цаг агаарын мэдээ, технологийн зөвлөмж, тоног төхөөрөмж, үр бордоо зэрэг орц материал, түүхий эд, бүтээгдэхүүний чанарын шаардлага, стандарт, боловсруулах үйлдвэрлэлийн холбогдолтой мэдээлэл г.м.,
- Зах зээлийн мэдээлэл: ХАА-н түүхий эд, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт, үнэ ханш, борлуулалтын сувгууд, гадаад худалдаа г.м.
- Эрдэм шинжилгээний мэдээлэл: ХАА-н салбарт буюу холбогдох бусад салбарт гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын урьдчилсан ба нэгдсэн үр дүн, холбогдох бусад мэдээлэл.

Мэдээлэл аливаа шийдвэрийг гаргах үндэс суурь нь болох тул ХАА-н үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай хүчин зүйлд тооцогдоно. Мэдээлэл хомсодвол ХАА-н үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашиг буурч, улмаар нийт салбарын тогтвортой байдал ба хүн амын хүнсний баталгаат байдалд сөргөөр нөлөөлдөг. Иймд ХАА-н салбарт ямар нэг үүрэг, хариуцлага хүлээсэн нийт оролцогч талуудыг баталгаатай, чанартай, хэрэгцээтэй мэдээллээр цаг тухайд нь хангах нөхцлийг бүрдүүлэх нь тус салбарын хөгжлийн нэг чухал шалгуур үзүүлэлт юм.

Хөдөө аж ахуйн мэдээллийн эх үүсвэрүүд ба мэдээлэл түгээх сувгууд

ХАА-н салбарт ажиллаж буй бүх иргэд, байгууллага, ААН-үүд мэдээллийг бий болгодог боловч үнэн зөв байдлыг нь хариуцах чадвараараа харилцан адилгүй. Иймд ХАА-н мэдээллийн эх үүсвэрийг албан ба албан бус гэж ангилдаг.

ХАА-н мэдээллийн албан эх үүсвэрүүд:

- ХАА-н салбар дахь төрийн захиргаа, хяналт, үйлчилгээний байгууллагууд
- Төрийн өмчит боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагууд
- Төрийн оролцоо бүхий байгууллага, ААН-үүд, жишээ нь ХАА-н бирж ТӨХК, ХАА-н давхар даатгал ХК, Тариалан эрхлэлтийг дэмжих сан г.м.
- ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн улс, орон нутгийн төвшний холбоо, нийгэмлэгүүд
- ХХААХҮЯ-ны хяналт дор хэрэгждэг олон улсын төсөл, хөтөлбөрүүд

ХАА-н мэдээллийн албан бус эх үүсвэрүүд:

- Хэвлэл мэдээллийн байгууллагууд
- ХАА-н салбарт ажилладаг ТББ-үүд ба хувийн хэвшлийн ААН-үүд
- ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчид
- ХАА-н мэдээлэл түгээдэг бусад иргэд, байгууллага, ААН-үүд

Мэдээллийн чанар эх үүсвэрээсээ тэр бүр хамаардаггүй. Харин албан бус эх үүсвэрийн мэдээлэлтэй холбоотой гол асуудал бол тухайн мэдээллийн үнэн зөв байдал баталгаагүй буюу эргэлзээтэй байдаг явдал юм.

ХАА-н мэдээллийг дараахь сувгуудаар түгээж байна:

1. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд
 - Радио
 - Телевиз
 - Олон нийтэд зориулан хэвлэгддэг сонин, сэтгүүлүүд



2. Интернет
 - Цахим хуудас
 - Сошл сүлжээ (facebook, youtube, twitter г.м.)
3. Салбарын төрөлжсөн хэвлэл
 - Ном, гарын авлага, каталог
 - Зурагт хуудас, плакат, нугалбар
 - Эрдэм шинжилгээний сэтгүүл, товхимол
 - Салбарын сонин, сэтгүүл (“Монголын хөдөө” сонин, “Шинэ өсөлт” сэтгүүл)
4. Сургалт, мэдээллийн арга хэмжээнүүд (сургалт, хурал, зөвлөгөөн, семинар г.м.)
5. Хүмүүс хоорондын харилцаа (хөршүүдийн, хамтран ажиллагсдын, бизнесийн түншүүдийн хоорондох г.м.)

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээллийг олон хүнд бага зардлаар хүргэдэг. Монголд хамгийн өргөн цар хүрээтэй хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол телевиз юм. Хот, хөдөөгийн ихэнхи өрхүүд телевизийн кабель буюу зайны хүлээн авагчтай бөгөөд зурагтаар тогтмол мэдээлэл авдаг (Chuluunbaatar et al., 2017). Олон нийтэд зориулан хэвлэгддэг сонин, сэтгүүлүүд ч бас ХАА-н мэдээлэл түгээхэд зохих үүрэг гүйцэтгэдэг.

Интернэт: Монгол улсад ухаалаг гар утасны хэрэглээ ба интернэт холболтын хамрах цар хүрээ нэмэгдсэнээр YouTube, Facebook зэрэг сошл сүлжээнүүдийг идэвхтэй хэрэглэх болсон бөгөөд цаашид уг хэрэглээ нэмэгдэх төлөвтэй байна (Hootsuite, 2019). Facebook-ээр шууд бичлэг цацах, Skype, WhatsApp, Viber, Line зэрэг харилцааны сүвгүүдээр яриа, лекц дамжуулах түршлага ч дэлгэрчээ. Цахим сүлжээнүүдийг мэдээлэл, зөвлөмж, түгээх, хэлэлцүүлэг, түршлага солилцоо болон зайны сургалтад ашиглахад нэн тохиромжтой.


Салбарын төрөлжсөн хэвлэлийг сургалт, сурталчилгаа, мэдээллийн зориулалтаар, тодорхой зорилтот бүлгүүдэд зориулан бэлтгэдэг. Гол давуу тал нь уншигчид олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон интернэтээс авсан мэдээллийнхээ үнэн зөв эсэхэд эргэлзэх нь түгээмэл байдаг бол ном, гарын авлага, салбарын сонин, сэтгүүлд агуулагдах мэдээлэлд итгэж үнэмших нь илүүтэй байдаг. Иймд цахим мэдээллийн сүвгүүдыг ашиглах нь нэмэгдэж буй хэдий ч салбарын хэвлэлийн бүтээгдэхүүнүүдийн хэрэгцээ шаардлага цаашид ч байсаар байх болно. Сонин, сэтгүүлийн хувьд ХААИС-иас “Монголын хөдөө” сонинг улирал тутам гаргаж байна. Мөн сүүлийн үед “Шинэ өсөлт” сэтгүүл тогтмол хэвлэгдэх болжээ.

Сургалт, мэдээллийн арга хэмжээнүүдийг тодорхой сэдвээр зохион байгуулж, тодорхой зорилтот бүлгүүдийн төлөөллийг хамруулдаг. Уг арга хэмжээнүүд оролцогчдод мэдээллийг үүгүүл буюу баталгаатай эх үүсвэрээс шууд авах боломж олгохоос гадна ойлгоогүй зүйлсээ асууж тодруулах, харилцан ярилцах боломж олгодог тул мэдээллийн солилцоо эрчимтэй явагддаг. Оролцогчид түүнчлэн арга хэмжээнээс олж авсан мэдээлээ хамтран ажиллагсад, хөрш зэргэлдээ малчид, тариаланчидтайгаа хуваалцах боломжтой тул тэдгээрийг “мэдээлэл олшруулагчид” гэж үзэж болно.



Хүмүүс хоорондын харилцаа мэдээлэл түгээх хамгийн хүчирхэг суваг болох нь судалгаагаар нотлогджээ (жишээ нь Sivayogonathan ба Tedrick, 1986; Goswami ба Sarkar, 2009). Хүмүүс ойр дотныхноосоо, хөршүүдээсээ, ажил төрлийн буюу бизнесийн ойрын хамтрагч, түншүүдээсээ авсан мэдээлэлд хамгийн их итгэж, уг мэдээллээ хамгийн сайн тогтоож авдаг байна. Хүмүүс хоорондын харилцаа ихэвчлэн харилцан ярианы хэлбэрээр, өөрөөр хэлбэл эргэх холбоотой явагддаг тул мэдээлэл солилцооны хамгийн эрчимтэй сувагт тооцогддог.

ХАА-н мэдээлэл түгээхэд ашиглагддаг дээрх сувгуудын давуу ба сул талуудыг 1-р зурагт харьцуулав. Мэдээллийн баталгаат ба хэрэгцээт байдлын хувьд сургалт, мэдээллийн арга хэмжээнүүд болон салбарын хэвлэлийн бүтээгдэхүүнүүд мэдээлэл түгээх бусад сувгуудаас давуу болох нь харагдаж байна. Интернет сувгууд мэдээллийг хамгийн өндөр хурдаар дамжуулдаг. Харин олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон хүмүүс хоорондын харилцаа нь мэдээллийг бага зардлаар олон хүнд хүргэж чаддагаараа бусад сувгуудаас ялгардаг. Нийтэд нь авч үзвэл мэдээлэл түгээх суваг бүр өөрийн давуу ба сул талуудтай учраас ХАА-н мэдээллийг түгээх “хамгийн сайн” суваг, хэрэгсэл гэж үгүй. ХАА-н холбогдолтой төрөл бүрийн мэдээллийг төрөл бүрийн зорилтот бүлгүүдэд хүргэх шаардлагатай байдаг учраас мэдээллийн бүх сувгуудыг хослуулан ашиглах, тухайн мэдээллийн төрөл, агуулга, зорилтот бүлэгт тохирсон сувгийг сонгох зарчмыг баримтлах нь зүйтэй.



Зураг 1. Хөдөө аж ахуйн мэдээлэл түгээх суваг, хэрэгслүүдийн давуу ба сул талууд, 4 онооны шкалаар үнэлснээр (1-хамгийн бага, 4-хамгийн өндөр)

Хөдөө аж ахуйн мэдээллийн хүртээмж, чанарыг сайжруулах асуудал



ХАА-н салбар дахь мэдээллийн тогтолцоог сайжруулах зорилгыг мэдээллийн хангамж ба чанарыг сайжруулах гэсэн зорилтуудад задлан авч үзэж болно. Эдгээр зорилтуудыг биелүүлэхэд бодлого, эрх зүйн, институцийн таатай орчин, ХАА-н салбарын төрөл бүрийн оролцогч талуудын хамтын ажиллагаа шаардагдана. Зарим улс орнуудад (жишээ нь Замбид) мэдээлэл түгээх ажлыг хариуцсан тусгай нэгж, агентлаг ажилладаг бол БНХАУ, Серби зэрэг зарим орнууд ХАА-н мэдээллийн тогтолцоог төрөөс хэрхэн зохицуулах талаар тодорхой заалтуудыг ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний тухай хуульдаа тусгасан байна. Уг загваруудыг Монголд нэвтрүүлэх эрх зүйн зохицуулалт одоогоор байхгүй тул ХАА-н мэдээллийн хүртээмж, чанарыг сайжруулахад чиглэсэн доорх зөвлөмжүүд одоогийн байгаа бүтцийг чадавхижуулах, хүчин чадал, үр дүнг нь нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим орчинд мэдээлэл түгээх цар хүрээг нэмэгдүүлж, түгээлтийг боловсронгуй болгоход чиглэсэн зөвлөмж

Салбарын сонин, сэтгүүл ба олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй тогтмол хамтран ажиллах – ХАА-н салбарт 1990 оноос хойш салбарын сонин, сэтгүүл бий болгох олон санаачлагууд гарсан боловч одоо үлдсэн ганц хэвлэл нь “Монголын хөдөө” сонин юм. Мөн 2019 оноос хэвлэгдэж эхэлсэн “Шинэ өсөлт” сэтгүүл ямарваа дэмжлэггүйгээр ажиллаж, тус салбарт өөрийн байр суурийг эзэлж чадсан амжилтыг үнэлэх нь зүйтэй. Гэвч өнгөрсөн 30 жилийн сургамжаас үзвэл энэ хоёр хэвлэлээ цаашид тасалдуулахгүй авч үлдэхэд бодлогын дэмжлэг зайлшгүй шаардагдана. Нөгөө талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ХАА-н мэдээллийг хэдийгээр түгээж буй боловч түгээлт нь тогтмол бус байгааг цаашид залруулах шаардлагатай байна. Иймд бодлого боловсруулагчдын зүгээс “Монголын хөдөө” сонин, “Шинэ өсөлт” сэтгүүл болон орон нутагт үзэгч, уншигч харьцангуй ихтэй телевизийн суваг, сонинуудтай тогтмол хамтран ажиллах, үүний тулд ХАА-н салбарын мэдээлэл, сурталчилгааны ажлыг жил бүрээр багцлан төлөвлөж, шаардагдах төсвийг ХХААХҮЯ, бусад эх үүсвэрүүдээс бүрдүүлдэг жишиг нэвтрүүлэх нь зүйтэй.

Мэдээллийн цахим сүлжээг боловсронгуй болгох – Интернэтээр мэдээлэл түгээх түршлага дэлгэрч буй нь сайшаалтай боловч үүнд тулгарч буй асуудал нь мэдээллийн эмх цэгцгүй байдал юм. Ялангуяа сошл сүлжээнүүдэд хэрэглэгч бүр мэдээлэл нийтлэх боломжтой боловч мэдээллийнхээ үнэн зөв байдлыг хариуцах тогтолцоо төлөвшөөгүй тул сүлжээгээр цацагдаж буй асар их мэдээллээс баталгаатай, үнэн зөв мэдээллийг шүүж ялгахад төвөгтэй байна. Иймд бодлого боловсруулагчид болон ХАА-н үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо, нийгэмлэгүүдийн зүгээс ХАА-н цахим мэдээллийг тодорхой бүтцэд оруулж цэгцлэх, баталгаатай, үнэн зөв мэдээллийн хаяг, эх сурвалжийг хэрэглэгчдэд ойлгомжтой болгох асуудалд анхаарал хандуулах шаардлагатай. Юуны өмнө баталгаат эх үүсвэрийн мэдээлэл олон сайт, сошл сүлжээнүүдэд тархаж байршсаныг цөөн тооны нэгдсэн сүлжээнүүдэд төвлөрүүлэх нь зүйтэй. Ийм нэгдсэн сүлжээнүүдийг жишээлбэл ХААҮШУОНТ-ийн ажиллуулдаг ХАА-н мэдээллийн портал www.agrinformn болон НҮБ-ын ХААБ-ын бүтээсэн ХАА-н цахим номын сан <http://books.xxaa-zainii-surgalt.mn> зэрэг нэгэнт бий болсон санаачлагуудад тулгуурлан бий болгож болно. Нэгдсэн сүлжээг мэдээллийн үүл (cloud) хэлбэрээр



ажиллуулах, өөрөөр хэлбэл төрөл бүрийн сайт, сүлжээнүүдэд нийтлэгдсэн мэдээлэл нэгдсэн сүлжээнд автоматаар хуулбарлагдан нийтлэгдэж байхаар зохион байгуулах боломжтой. Мөн Европын Холбооны санхүүжилттэй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-өөс боловсруулах үйлдвэрлэл дэх хөдөлмөр хамгаалал (жишээ нь “Хүхэрт үстөрөгчтэй харьцах”) болон малын арьс өвчих, хонь хяргах сэдвүүдээр бэлтгэсэн онлайн сургалт, ХААИС-иас бэлтгэсэн “Цахим аяны богц” зэрэг ХАА-н салбарт нэвтэрч буй цахим сургалт, мэдээллийн санаачлагуудад үнэлэлт дүгнэлт өгч, хэрэглээг нь төлөвшүүлэх талаар бодлогын төвшинд зохих санаачлага үгүйлэгдэж байна.

ХХААХҮЯ-ны бүтэц дэх мэдээлэл, сурталчилгааны байгууллага, нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн зөвлөмж

ХХААХҮЯ-ны хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны бүтэц, үйл ажиллагааг бэхжүүлэх – Хууль, журам, бодлогын шийдвэрүүдийн хэрэгжилт, үр дүнг сайжруулахын тулд холбогдох мэдээллийг зорилтот бүлгүүдэд нь цаг тухайд нь, зохистой агуулга, хэлбэрээр хүргэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна. Мэдээллийн агуулга, хэлбэрийн тухайд үйлдвэрлэлд ажиллаж буй малчид, тариаланчдад хууль, журмыг эх хувилбараар нь уншуулахаас илүүтэйгээр хялбаршуулсан агуулга бүхий мэдээллийг текст, зураг, анимейшн, дүрс бичлэг хослуулан, аль болох ойлгомжтой хэлбэрээр бэлтгэж түгээдэг жишгийг нэвтрүүлэх нь зүйтэй. Мэдээлэл түгээхэд зорилтот бүлгээс хамаарч гарын авлага, брошюр, мэдээллийн хуудас зэрэг уламжлалт хэрэгслүүдээс гадна телевиз, радио, цахим сүлжээнүүд, гар утасны апп зэрэг шинэлэг суваг, хэрэгслүүдийг ашиглаж болно. Энэ төрлийн мэдээллийн эх үүсвэр нь ХХААХҮЯ болон тус яамны харъяа байгууллага, нэгжүүд учраас мэдээлэл бэлтгэх, түгээх ажлыг ХХААХҮЯ-ны хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба хариуцахад тохиромжтой. Төрийн захиргааны удирдлагын газрын харъяанд, одоогоор ганцхан ажилтантайгаар ажиллаж буй уг албыг ойрын хугацаанд мэдээлэл, харилцаа, дуу, дүрс бичлэгийн төхөөрөмжөөр иж бүрэн тоноглож, одоо ажиллаж буй сэтгүүлчээс гадна мэдээний редактор, зураглаач болон цахим мэдээллийн мэргэжилтэн зэрэг 4-өөс цөөнгүй хүний бүрэлдэхүүнтэй болгон өргөтгөх нь зүйтэй. Тоноглол, хүний нөөцийн хувьд түүнчлэн БОАЖЯ болон ЭМЯ-ны хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албадаас жишээ авах боломжтой.

ХААҮШУОНТ-ийн цахим мэдээллийн үйл ажиллагааг өргөтгөх, ХАА-н мэдээллийн нэгдсэн сан бий болгож, хариуцуулах – ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний төв байгууллага ХААҮШУОНТ ХАА-н мэдээллийн тогтолцоонд чухал байр суурь эзэлдэг. Тус төв ХАА-н үйлдвэрлэлийн технологи, менежментийн сэдвүүдээр мэдээлэл, зөвлөмж бэлтгэж, ном, гарын авлага, бусад хэвлэлийн бүтээгдэхүүнүүд, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон цахим сүлжээнүүдээр түгээдэг. Төвийн мэдээллийн үйл ажиллагаанд цаашид дараахь чиглэлүүдийг нэмж багтаах санал дэвшүүлж байна. Үүнд:

- ХАА-н мэдээллийн нэгдсэн сан бий болгож, зохицуулалт, үйлчилгээг хариуцах;
- Албан эх үүсвэрээс бэлтгэсэн ХАА-н цахим мэдээллийн нэгдсэн зохицуулалтыг хариуцах.

ХАА-н мэдээллийн санг бий болгох, тогтмол шинэчлэх, ашиглах ажлыг тус төвд ХХААХҮЯ-наас хариуцуулж, шаардагдах төсвийг олгох нь зүйтэй. Уг мэдээллийн сан нь бодлого боловсруулахад



болон эрдэм шинжилгээ, нэвтрүүлэх үйлчилгээнд чухал ач холбогдолтой. ХАА-н цахим мэдээллийн нэгдсэн зохицуулалтыг хариуцах тухайд хамгийн боломжит хувилбар нь төвөөс нэгэнт ажиллуулж буй www.agrinfo.mn цахим порталыг дээр дурдсан мэдээллийн үүл хэлбэрт шилжүүлж, салбарын төр, захиргаа, боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагууд болон бусад албан эх үүсвэрүүдээс бэлтгэсэн мэдээллийг уг порталд төвлөрүүлэн нийтлэх хувилбар юм.

Хөдөө аж ахуйн мэдээ, мэдээлэл бэлтгэх хүний нөөцийг чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн зөвлөмж

Салбарын сэтгүүлчид, бусад мэдээлэл бэлтгэгчдийг сургалтанд хамруулж чадавхжуулах – ХАА-н мэдээллийн чанарыг сайжруулахын тулд ХХААХҮЯ, ХААҮШУОНТ болон холбогдох бусад байгууллагуудын мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүд болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд ХАА-н мэдээ, мэдээлэл бэлтгэдэг сэтгүүлчдийг чадавхижуулах шаардлагатай байна. Уул уурхайн салбарт Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн (GIZ) хэрэгжүүлж буй “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” төслийн хүрээнд уул уурхайн мэдээ, мэдээлэл бэлтгэдэг сэтгүүлчдийг цуврал сургалт, Австрали улсад туршлага судлах аялалд хамруулсан туршлага бий. Уг туршлагад үндэслэн ХАА-н салбарт ч бас хэвлэлийн мэдээ, мэдээлэл, цахим контент бэлтгэх сургалт зохион байгуулж, уншигчдад хүрэх мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах нь зүйтэй (эх сурвалж: “Шинэ өсөлт” сэтгүүлийн эрхлэгч И.Отгонжаргал, ярилцлага).

ХАА-н үйлдвэрлэгчдийг цахим мэдээлэл ашиглах, бэлтгэх зайны сургалтад хамруулах – Цахим сүлжээгээр мэдээлэл түгээх хандлага нэмэгдэж буй өнөө үед компьютер, ухаалаг утас, таблет зэрэг мэдээлэл, харилцааны хэрэгслүүдийг зохистой ашиглаж сураагүй, цахим мэдээллийг хүлээн авах, хадгалах, бусдад дамжуулах, интернэтгүй орчинд ашиглах зэрэг үйлдлүүдийг бүрэн эзэмшиж амжаагүй малчид, тариаланчид олон байгаа нь цаг үеийн шаардлагад нийцэхгүй байна. Түүнчлэн өөрсдөө цахим сүлжээнд хүнд ойлгомжтой мэдээлэл бэлтгэж нийтлэх чадвар дутмаг байна. Иймд ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд цахим мэдээлэлтэй харьцах болон мэдээллийн контент бэлтгэх суурь ур чадвар олгох сургалтыг зохион байгуулах нь зүйтэй. Ийм сургалтыг зохион байгуулах чадвартай дотоодын олон байгууллага байдаг. Сургалт олон мянган малчид, тариаланчид, фермерүүдэд зориулагдах тул цахим хэлбэрээр бэлтгэж, орон нутагт хамгийн их ашиглагддаг цахим сүлжээнүүдээр дамжуулан хүргэх нь тохиромжтой.



Ашигласан хэвлэл

Chuluunbaatar, D., Annor-Frempong, C. and Gombodorj, G. (2017): Mongolia: A review of the agricultural research and extension system. Rome: Food and Agriculture Organization of the United Nations Rome (FAO). URL: <http://www.fao.org/3/a-i6571e.pdf>

Goswami, R. and Sarkar, A. (2009): Interpersonal communication pattern of farmers through key communicators regarding some selected Gram Panchayat activities. In: Journal of Interacademia, Vol.14 (2), pp. 254-259. URL: <https://mpira.ub.uni-muenchen.de/25983>

Hootsuite (2019) Digital 2019 Mongolia. URL: https://www.slideshare.net/DataReportal/digital-2019-mongolia-january-2019-v01?fbclid=IwAR2kGgF0JsD8OqdWx63_YTdUYQKTqJJASnOZncR2rk3GojIBPcJAWn3J0t8

Sivayoganathan, C. and Tedrick, William E. (1986): Interpersonal communication in the adoption process. In: Journal of Applied Communications, Vol. 69 (4). <https://doi.org/10.4148/1051-0834.1623>

Тайлбар: Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 19-01) төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Зохиогчид

Б.Эрдэнэболор, PhD
Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн мэргэжилтэн
Имэйл: erdenebolor@iakleipzig.de

Кэвин Д.Галлагер, PhD
Future of Agriculture (Asia), Virtual Think Tank

Альфред Катер, PhD
Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн удирдагч
Имэйл: a.kather@iakleipzig.de